МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН БОДЛОГЫН УЯЛДАА ХОЛБОО, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Ц. Нороводондог (Ph. D), Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа, Ц. Болормаа, Г. Билгээ

Агуулга:

1. Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онолын сургаалиудын харьцуулалт, чиг хандлага
2. Монгол улсын нийгэм - эдийн засаг дахь төрийн бодлого, хэрэгжилт, үр дүн, уялдаа холбоо
   2.1 Монгол улсын төрийн бодлогын стратеги зорилт, тэдгээрийн уялдаа холбоо
   2.2 Монгол улсын нийгэм - эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төрийн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
3. Төрийн бодлого ба иргэдийн оролцооны асуудал
4. Дүгнэлт, зөвлөмж

* * *

Оршил

Монгол улс сүүлийн 20 гаруй жилийн туршид нийгэм - эдийн засгийн тогтолцоогоо зах зээлийн эдийн засгийн зарчимд нийцүүлэх шилжилтийн эдийн засгийн болон тогтворжуулалтын бодлогыг хэрэгжүүлж, улмаар эдийн засгийн өсөлтийг хангасны үндсэн дээр хүний хөгжилд тулгуурласан нийгмийн чиг баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх зорилт тавин хэрэгжүүлж байна. Гэвч төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог бүрэн шинэчилж эдийн засаг, нийгмийн харилцааны цоо шинэ дэглэмийг тогтоох процесс Монгол улсад хэрхэн явагдаж байгаад дүн шинжилгээ хийх, төрийн бодлогын онолын үзэл баримтлал, уялдаа холбоо болон практик үр дүнг харьцуулан судлах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Асуудлыг судлахдаа төрийн нийгэм эдийн засгийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онолын чиг баримжаа нь ямар байгааг тодруулах, өнгөрсөн хугацаанд төрөөс явуулсан бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, уялдаа холбоо, мөн иргэний нийгмийн оролцоо ямар байгааг судалгаагаар харуулахыг зорьсон болно.

1. Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онолын сургаалиудын харьцуулалт, чиг хандлага

Нийгэм-эдийн засаг дахь төрийн бодлогын уялдаа холбоо нь үндсэндээ эдийн засагт гүйцэтгэж буй төрийн үүргийн тухай асуудал юм. Онолын хувьд меркантилизмаас авахуулаад неоинституционализм, орчин үеийн нийгмийн ардчилсан үзэл/ социал демократизм/ хүртэл онолын сургааль үзэл баримтлалууд бүрэлдэн бий болж хөгжлийн шат бүхэнд өөрийн өвөрмөц загвар, практик хэрэглээг бий болгосон бөгөөд тухайн онол, үзэл баримтлал бүрт эдийн засагт гүйцэтгэх төрийн үүрэг роль харилцан адилгүй байсан байна. Практикаас харахад, улс орон бүр өөрийн орны хөгжлийн өвөрмөц нөхцөл байдал, урт болон богино хугацааны зорилтоосоо хамааран төрийн үүрэг ролио тодорхойлсон байдаг.

Зах зээлийн эдийн засаг дахь нийгэм-эдийн засгийн харилцаа нь нэг талаас, аж ахуйн

харилцаанд орж буй субьектуудын харьцангуй “эрх чөлөөтэй” байх обьектив хүсэл сонирхол, нөгөө талаас нийтийн эрх ашгийн үүднээс төрийн бодлогоор “дэглэм” тогтоох субьектив сонирхолын харилцан хамаарлаар илэрч байдаг. Төрийн зүгээс эдийн засгийн суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн харилцаанд оролцогч субьектуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, нийгэм-улс төрийн тодорхой зорилго, зорилтыг ханган биелүүлэх үүргийг хүлээнэ.

Төрийн оролцоо, үүрэг роль нь эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээг тогтооход оршино. Төр үүргээ биелүүлэхдээ өмчлөгч хэлбэрээр эдийн засгийн харилцаанд шууд оролцох буюу эсвэл зах зээлийн механизмуудыг ашиглан шууд бусаар оролцож байдаг. Гэвч орчин үед төрийн зохицуулалт нь улам бүр хэлбэржиж, комплекс шинж чанартай болж байна. Тухайлбал:

- Төрд материаллаг болон мөнгөн хөрөнгийн ихээхэн хуримтлал бий болж, эдийн засгийн болон захиргааны арга хэрэгсэлүүдийг ашиглан эдийн засгийн гадаад болон дотоод хүчин зүйлд нөлөөлөх боломжтой болсон учраас төрийн бодлого илүү төвлөрсөн шинжтэй болж байна.
- Төрийн зүгээс урт болон богино хугацаанд бодлого , хөтөлбөр хэрэгжүүлж аж ахуйн үйл ажиллагааны бүх түвшинд, бүх салбарт нөлөө үзүүлэх боломжтой учраас зохицуулалтын цар хүрээ нь өргөн байна.
- Төрийн бодлого, үйл ажиллагаа тасралтгүй тогтмол шинжтэй болсон.
- Төрийн зүгээс эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон захиргааны олон арга хэрэгсэлүүдийг ашиглах боломжтой болсон.

Практикаас үзэхэд, төрийн бодлого тодорхойлох үйл явц нь нарийн төвөгтэй , илүү шинжлэх ухаанд тулгуурласан байх шардлагатай ба ийм ч учраас нэр хүнд бүхий эдийн засагчид, шинжлэх ухааны томоохон зүтгэлтнүүдийг төрийн бодлого тодорхойлох үйл ажиллагаанд татан оролцуулах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч Кеннедигийн 16 эдийн засгийн зөвлөхийн нэг нь П.Самуэлсон, Ерөнхийлөгч Рейганы эдийн засгийн зөвлөх нь М.Фридман нар байжээ.

Эдийн засгийн онол бол зүй тогтолт хөгжлийн загвар, сайтар бодож боловсруулсан бодлого, хөтөлбөр юм. Онол өөрөө өөрчлөгдөн хувьсаж улам бүр боловсронгуй болсоор байна. Иймд онолын урсгалууд дахь төрийн үүрэг ролийн талаархи үзэл баримтлалуудыг харьцуулан судлах нь хөгжлийн зөв тактик, бодлогын хувилбарыг тодорхойлоход тустай юм. Иймд сэдвийн хүрээнд онолын сургаалиудыг харьцуулан судалж, тэдгээрийн онцлогийг практик хэрэглээ талаас нь системчлэн харуулсан болно.

- 15-р зууны үед бий болсон **меркантилист** онолд(гол төлөөлөгчид-)анх удаа эдийн засаг дахь төрийн үүрэг роль, зорилго, арга хэрэгсэлүүдийг тодорхойлсон байдаг.
  - Төр нь зах зээлийн эдийн засаг хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн бүх хэлбэр чөлөөтэй оршин тогтнох эрх чөлөөг олгох
  - Төрийн зүгээс анхны капиталын хуримтлал болон шинэ анги давхаргуудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх
  - Төр үүргээ гүйцэтгэхийн тулд хүчтэй, шийдвэртэй,хатуу төвлөрсөн бодлоготой байх ба зах зээлийн механизмтай үйл ажиллагаагаа уялдуулах шаардлагатай гэж үзсэн

- **Классик онол** (Гол төлөөлөгчид – А. Смит, Д. Рикардо) нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн онол юм. Зах зээлийг үл үзэгдэгч гар удирдах ба зах зээл өөрөө өөрийгөө зохицуулах чадвартай гэж үздэг. Уг онолоор эдийн засаг дахь төрийн оролцоог үндсэнд нь үгүйсгэх ба төрийн зүгээс зөвхөн:
  - Улс оронд дэг журам тогтоох

- Улс орны гадаад аюулгүй байдлыг хангах
- Төрийн санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн явуулах
- Засгийн газрын зайлшгүй зардалыг нөхөх хэмжээнд татварын хувь хэмжээг тогтоох

ёстой гэж үздэг.

- **Марксист онолд** (гол төлөөлөгчид- К. Маркс, Ф. Энгельс төрийн бодлогын эдийн засгийн болон улс төрийн хүчин зүйлийн харилцан хамаарлыг гаргаж ирсэн. Эдийн засгийн хүчин зүйл шийдвэрлэх нөлөөтэй боловч улс төрийн хүчин зүйл үүнд нөлөөлнө, төр засаг бие даасан үүрэг рольтой гэж үзсэн. Хөрөнгөтний нийгмийг чөлөөт коммунист нийгмээр солих шилжилтийн эдийн засгийн бодлого хөтөлбөр нь өмч хөрөнгө, эрх мэдлийг төр засагт төвлөрүүлж төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны үндсэн дээр бүх хүмүүс тэгш хөдөлмөрлөх, тэгш хүртэх зарчим дээр тулгуурласан байна.

- **Неоклассик онол** (гол төлөөлөгч - А. Маршалл) нь классик онолын үргэлжлэл бөгөөд чөлөөт өрсөлдөөний эдийн засаг нь дотоод мөн чанараараа тогтвортой байдаг, төрийн зохицуулалт шаардлагагүй гэж үздэг. Төрийн бодлогоор эдийн засгийг тогтворжулах оролдлого нь үр ашиггүй бөгөөд энэ нь нийт эрэлтэд нөлөөлөх боломжгүй. Зах зээл өөрөө өөрийгөө зохицуулах зарчим нь төрийн оролцоог бүрэн үгүйсгэдэг. Төгс өрсөлдөөний зах зээлд төрийн оролцоо шаардлагагүй, төгс бус өрсөлдөөний үед төр оролцож өрсөлдөж буй үйлдвэрлэгчдийг зохицуулах ёстой. Жишээ нь:
  - Зүй ёсны монопольд төрийн зүгээс үнийг хянах, үнэ тариф тогтоох, алдагдалыг төсвөөс санхүүжүүлэх, буцаан нийгэмчлэх гэх мэтээр зохицуулалт хийх.
  - Тэнцвэржүүлэх татвар, татаасын бодлого хэрэгжүүлэх. Үйлдвэрлэлийн явцад нийтийн эрх ашигт хохирол учрах, эсвэл боломж нэмэгдэх үед авдаг нэмэлт татвар тогтоох буюу компенсаци олгох.
  - Нийтийн хэрэглээнд зориулан нөөц бүрдүүлэх (батлан хамгаалах, байгаль орчин, дэд бүтэц, нийгмийн хэв журам сахиулахад гэх мэт)

Неоклассик онолоор үндэсний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд микро эдийн засгийн онолын үүднээс төр дараахь бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Чөлөөт өрсөлдөөний орчинг бүрдүүлэх
- Мөнгөний массыг тогтвортой байлгах /орлого, зарлага төсвийн алдагдалаа хянах/
- Гадаад эффектэд компенсаци хийх
- Нийтийн хэрэглээний нөөц бүрдүүлэх
- ОУ-ын төлбөр тооцоо, валютын ханшийг зохицуулах

- **Кейнсийн онолд** (Дж. Кейнс, А. Маршалл) эдийн засгийн шинжлэх ухааны онолд төрийн оролцоог илүү тодорхой болгосон байдаг. Дайны дараахь үе, хямралын үеүдэд эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн оролцоо илүү чухал байсан тул:
  - Төсвийн зардлыг бууруулах, орлого зардлыг тэнцвэржүүлэх
  - Төсвийн алдагдалыг ЗГ-ын үнэт цаас болон эмиссийн аргаар санхүүжүүлэх
  - Мөнгө-зээлийн бодлогыг төсвийн бодлоготой нийцүүлэх гэх мэтийн макро эдийн засгийн бодлого явуулах. Ингэхдээ Төв банк инфляцийг дарангуйлах мөнгөний хатуу бодлогоос илүүтэй үр ашигтай эрэлтийг дэмжсэн бодлогыг эдийн засгийн мөчлөгт тохируулан явуулах шаардлагатай гэж үздэг. Кейнсийн онолд төсөв-мөнгөний бодлогыг уялдуулах, ингэхдээ төсвийн хатуу бодлого, мөнгөний зөөлөн

бодлого явуулах нь үр ашигтай гэдгийг нотолсон.

- **Неолиберализм онол** (Людвиг Эрхард Баруун Герман) нь дэлхийн 2-р дайны дараагаас 60-70 оны хямралын үе хүртэл Баруун Германд хэрэгжүүлсэн эдийн засгийн бодлого юм. Дайны дараахь эмх замбараагүй байдлыг цэгцлэх үүднээс реформын шинжтэй хэд хэдэн арга хэмжээг төрийн зүгээс авч хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн. Тухайлбал:
  - Эдийн засгийн шинэчлэлийг мөнгөний бодлогын шинэчлэлтэй хамтруулан явуулж 100 рейсмаркийг 6,5 ДМ -аар солих, өрийг хүчингүй болгох, Засгийн газраас хараат бус төвлөрсөн банкийг байгуулах зэргээр инфляцийг бүрэн хяналтанд авсан.
  - Нийгмийн шинжтэй томоохон реформуудыг хүрээнд ажиллах хүчний чөлөөт зах зээлийг бий болгох, нийгмийн даатгалын системийг өөрийгөө зохицуулах зарчимд шилжүүлэх, ажилчид болон эмзэг бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, орон сууцны хангамжийг сайжруулах, хувьд өмчлүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх гэх мэт..

- **Неоконсерватизм** (М. Фридман) 1970 аад оны үед АНУ (рейганомика) болон Англи (тетчеризм)-д амжилттай хэрэгжүүлсэн төрийн бодлого. Уг онолоор, зах зээл болон өрсөлдөөн нь зохицуулалтын хамгийн сайн механизм мөн боловч урт хугацаандаа нийлүүлэлтийг дэмжсэн төрийн зохицуулалт үр ашигтай гэж үздэг. Төрийн зохицуулалтын бодлого нь хэрэглээг биш хадгаламж, хуримтлалыг нэмэгдүүлэх, орлогын тэгш бус байдлыг арилгах, мөнгөний бодлого, татварын бодлогыг сайжруулах замаар төсвийн алдагдалыг бууруулах, инфляцийг тодорхой хэмжээнд зөвшөөрөх гэх мэт бодлогын арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн.

- **Институционализм (**У. Митчелл **)** Үүссэн шалтгаан нь нийгмийн чиглэлийн бодлогыг түлхүү анхаарах, хөгжиж буй орнуудын хөгжлийн эрс тэс ялгааг арилгах гэх мэтийн хүчийн зүйлс 20-р зууны дундуур бий болсон. Гол үзэл баримтлал нь эдийн засагт төрийн оролцоо буюу төлөвлөлтийн арга зайлшгүй бөгөөд хими, машин үйлдвэрлэл, электроник, шинжлэх ухааны салбар зэрэг салбарууд , өндөр технологид суурилсан эдийн засаг нь хөгжлийг хурдасгах гол түлхүүр гэж үзсэн. хүчин зүйл мөн гэж үздэг.

- **Неоинституционализм** (Р. Кроуз) 1970-аад оны сүүлчээр "нийтийн хэрэглээний нийгэм" гэх ойлголт бий болж зах зээлийн эдийн засгийн зохицуулалтын зарчмууд тодорхой болж эхэлсэн. Неоинституционал онолд улс төр судлал, эрх зүйн болон нийгмийн шинжлэх ухааны олон асуудлуудыг орчин үеийн микро эдийн засгийн онол болон тоглоомын онол, нийгмийн зөвшилцлийн онолын тусламжтайгаар тайлбарласан. Бие хүн бол анхдагч, институт-хоёрдогч боловч хувь хүний үйлдэл, ашиг сонирхолоос хамт олны, нийгмийн үйлдэл шалтгаална гэсэн ерөнхий санааг дэвшүүлсэн. Төрийн үүрэг ролийг төр – иргэн хоорондын эрх үүргийн хуваарилалтаар тодорхойлж Үндсэн хуулиар баталгаажуулсан явдал юм. Нийгэм - эдийн засаг - экологийн баримжаатай эдийн засаг хэмээх ойлголт бий болсон.

- **Социал демократизм** (Тони Блейр, Герхард Шрейдер,Билл Клинтон). 1980-аад оноос хойш нийгмийн хөгжлийн чиг хандлагыг зах зээлийн үр ашигтай систем ба нийгмийн хамгаалал, шударга ёсны чиг хандлагатай хослуулах тухай онолын үзэл баримтлал бий болсон. Уг үзэл баримтлалыг хэрэгжүүлэгч гол төлөөлөгчид нь Их британий ерөнхий сайд Тони Блейр, Германы канцлер Герхард Шредер, Билл Клинтон нар бөгөөд Социнтернийн гишүүн орнуудын улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгалаа олох болсон.

- Онолын хувьд, хөгжлийн ямарч үе шатанд, ямар ч ч түвшинд зайлшгүй баримтлах

төрийн бодлогын зарчим бол – зах зээлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн механизмуудын сөрөг үр нөлөөг бууруулахад чиглэгдсэн байх ёстой, өөрөөр хэлбэл, төрийн бодлого нь зах зээлийн бодит механизмтай байнгын зөвшилцөлд байх ёстой гэсэн нийтлэг зарчим юм.

Төрийн бодлого оновчтой, үр дүнтэй байх нь дараахь хэд хэдэн нөхцөлөөс шалтгаална. Үүнд:

- Зах зээлийн бодит механизм нь урсгалаар зохицуулагддаг учраас бодит нөхцөл байдлыг хурдан мэдэрч зохицуулж чадаагүйгээс төрийн бодлого шийдвэр **цаг хугацааны хувьд хоцорч гарах**, ингэснээр хямралыг үүсгэхэд хүрдэг
- Төрийн бодлого олон нийт, нийгмийн эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцээгүйгээс хэрэгжих боломжгүй болдог.
- Төрийн эдийн засгийн бодлогыг үр ашигтай болгохын тулд нийгэм дэх цөөнхийн эрх ашигт бус, **олон нийтийн эрх ашигт нийцсэн** бодлого шийдвэр гаргах,
- Төрийн бодлогыг боловсруулахдаа эдийн засгийн загварчлал, математик анализын аргуудыг ашиглан **эдийн засгийн төлөв байдлыг шинжлэх, прогноз** хийх шаардлагатай. Ингэснээр болзошгүй хямрал, бодит байдлыг мэдрэх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох улмаар шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах боломж бүрддэг.
- Төрийн эдийн засгийн бодлого үр ашигтай хэрэгжих нэг хүчн зүйл бол **бодлогын уламжлал** юм. Бодлогын уламжлал алдагдах нь төрий эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх чадвар дутмаг, хэт улс төржсөн байдлаас үүдэлтэй. Улс төрчдийн оролцоо хэдийчинээн бага байнав, төрийн бодлогын хэрэгжилт төдийчинээн сайн байна.

Макро эдийн засгийн бодлогын хувьд авч үзвэл, тулгамдсан олон асуудлуудыг шийдвэрлэх туйлын зөв ганц хариулт гэж үгүй. Төрийн бодлогыг аль нэгэн онолын чиг баримжаагаар явуулна гэдэг нь олон янзын онолын урсгалуудыг эмх замбараагүй хуулбарлан дууриах, хэлбэр төдий хэрэгжүүлэх, эсвэл аль нэг онолыг хатуу баримтлах тухай асуудал биш юм. Бодит нөхцөл байдал, ойрын болон урт хугацааны бодлого, зорилтдоо нийцүүлэн нэгтгэн боловсруулж, үр дүн өгөхүйц элементүүдийг нь сонгон авах, цогц байдлаар практикт хэрэгжүүлэх диалектик процесс юм.

Монгол улс 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжиж байх үед эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдал хүнд, туршлага дутмаг байсан учраас төрийн бодлогыг тодорхойлоход бэрхшээлтэй байсан. Гэвч 20 гаруй жилийн түүхэн хөгжлийн хугацаанд төрийн үүргийн тухай онолын болон практик ойлголт цэгцэрч төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах шаардлага улам нэмэгдэж байна.

2. Монгол улсын нийгэм эдийн засаг дахь төрийн бодлого, хэрэгжилт, уялдаа холбоо, үр дүн

Энэ асуудлын хүрээнд Монгол улсын нийгэм-эдийн засаг дахь төрийн бодлогын уялдаа холбоог дараахь асуудлуудын хүрээнд авч үзлээ. Үүнд:

- ✓ Монгол улсын төрийн бодлогын стратеги зорилт, тэдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоо
- ✓ Монгол улсын нийгэм-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төрийн бодлогын арга хэрэгсэлүүд, бодлогын хэрэгжилтийн үр дүн
- ✓ Төрийн бодлого тодорхойлоход иргэдийн оролцоо

2.1 Монгол улсын төрийн бодлогын стратеги зорилт, тэдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоо

Монгол улсад УИХ болон Засгийн газраас тогтоолоор баталсан 1000 гаруй бодлогын болон стратегийг баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг гэсэн статистик тоо байна. Үүнээс ЗГ-ын түвшинд хэрэгжиж байгаа үндэсний хэмжээний 177 төсөл, хөтөлбөр байгаагаас нийгэм, эдийн засгийн чиглэлийн 60 гаруй бодлогын хөтөлбөр хэрэгжиж байна. Монгол улсын хэмжээнд төрийн бодлого тодорхойлж буй стратегийн гол баримт бичгүүдэд тусгасан урт болон дунд хугацааны үндсэн зорилтууд нь:

1. УИХ-ын 1996.05.03 өдрийн №26 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” -д тусгаснаар Монгол Улс ойрын ирээдүйд оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын баримжаатай, харьцангуй биеэ даасан эдийн засагтай, үйлдвэржсэн орон болно”.

2. Энэхүү зорилтыг 1996-2020 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосон (1996-2000) онд эдийн засгийг тогтворжуулан сэргээж, цаашдын өсөлтийн үндсийг тавих, хөгжилд шаардлагатай хуримтлалыг бий болгох үе, (2001-2010) онд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн түүний экспортод баримжаалсан чиглэлийг хүчтэй болгох, (2010-2020) онд эдийн засгийн голлох салбаруудад үндэсний болон дэлхийн өндөр технологийг нэвтрүүлж Монгол Улсын өрсөлдөх чадварыг бий болгох, улмаар экспортод баримжаалсан оновчтой бүтэц бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай орон болох зорилтыг дэвшүүлжээ.

3. УИХ-ын 2008.01.31 өдрийн №12 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод−суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих 3 үе шатлалтай дараахь 6 тэргүүлэх чиглэл бүхий зорилтуудыг дэвшүүлсэн .

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг дор дурдсан зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх”-ээр зорилтоо дэвшүүдсэн байна. Үүнд:

- мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, монгол хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
- экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологт, суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно.
- стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглан хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй, өндөр өсөлтийг хангаж, орчин үеийн боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон арга чадавхийг бий болгох, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалах замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгоно.
- улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлнэ гэсэн байдаг.

Монгол Улсын хөгжлийн 2 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Монгол Улс экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өсөлт, хөгжлийн стратегийг сонгож байна”

4. УИХ -ын 2008.11.21 өдрийн №35 тоот тогтоолоор батлсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”–ийн 2 -т Үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилтыг дэвшүүлсэн .

5. УИХ-ын 2010.07.09 өдрийн №45 тоот тогтоол “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Хүний хөгжлийг хангах макро эдийн засгийн бодлого хүрээнд

   - Макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүний хөгжлийг хангахад чиглүүлнэ.
   - Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэнэ гэсэн зориултуудыг дэвшүүлсэн байна.

6. УИХ-ын 2010.07.15 өдрийн №48 тоот тогтоол “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” -д Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална.

7. Засгийн газрын 2009 оны 324 дүгээр тогтоолоор “Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийг батлсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь гадаад харилцааны арга хэрэгслээр эдийн засгийн өгөөжийг дэмжих, хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд гадаад бодлогын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.

Эдгээр бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн ямар байгаад хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн цэгцтэй мэдээлэл, судалгааны тайлан одоогоор алга байна. Төр засгийн бодлогыг оновчтой боловсруулах, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх нь нийгэм-эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх үндэс, суурь нь болдог.

Бодлогын зорилтот хөтөлбөрүүдийн үр дүнг сайжруулахад оролцогч талууд буюу Парламент, Засгийн газар, иргэд, хувийн салбар, ТББ, иргэний нийгэм, ОУБ, хандивлагч байгууллагуудын үүрэг роль их юм. Бодлого, төсөл, хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх нэг хэрэг, хамгийн гол нь “ ямар үр дүнд хүрэв” гэдгийг анхаарах, үүний тулд Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Төрийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн хүрээнд дараахь асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Үүнд:

- Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах. Төрийн бодлогын суурь концепц, түүнд нийцүүлэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэл, онолын чиг баримжаа болон практик үр дүнг тодорхой болгож, бодлого, зорилтуудыг зөв тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэрэгсэлүүдийг зөв тодорхойлох
- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах. Монгол улсад ижил зорилго, чиглэл бүхий маш олон бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа боловч тэдгээр нь агуулга, зорилтын хувьд давхардсан, эсвэл бие биенээ үгүйсгэсэн, уялдаа холбоо муутай байна гэх шүүмжлэл нэлээд гарч байна
- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох. УИХ болон Засгийн газраас батлан гаргаж буй бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байдгаас

хэрэгжилт нь хангалтгүй байдаг. Улс төрийн амлалт, нийгмийн сэтгэл зүйд нийцүүлэх хандлагатай олон янзын бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд цаасан дээр батлагдсан боловч хэрэгжих боломжгүй байсаар байна.

- Хяналт шинжилгээ-үнэлгээг сайжруулах. Сүүлийн үед төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарсан уламжлалт аргаас үр дүнд суурилсан хяналт шинжилгээ-шнэлгээний аргад шилжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар бодлого, хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн боловч хүсэн хүлээсэн үр дүнг бий болгож чадсан уу? гэдгийг анхаарах шаардлагатай. Үүний тулд төсөл, хөтөлбөрийн үр дагавар, үр нөлөөг тооцон гаргаж цаг хугацааны явцад зорилт биелэгдсэн эсэх, хэрхэн биелэгдэв гэдэгт хариулт өгөх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
- Иргэдийн оролцоог хангах. Ардчилсан засаглалын суурь зарчим болох сайн засаглал, хариуцлагатай, ил тод, нээлттэй байдлыг бий болгох үүднээс төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудал чухал юм. Хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох, нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад иргэд, олон нийтийн оролцоо чухал бөгөөд төр засгийн зүгээс гадад, дотоодын оролцогч талуудаас тавьж буй шахалт, шаардлагад илүү мэдрэмжтэй хандах шаардлага бий болж байна.
- Дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах. Дэлхий дахины эдийн засаг, зах зээлийн харилцаанд хүн амын, мэдээлэлийн болон бараа бүтээгдэхүүний асар их шилжилт хөдөлгөөн гарч хил хязгааргүй урсгалд татагдан орох даяаршилын шинэ нөхцөл байдал бүрдэж байгаа учраас хүн ам, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийн бодлого нь дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн үйл явцтай нягт уялдах шаардлагатай болж байна. дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал, хөрш орнуудын нөлөөлөл, уул уурхайн салбарын хөгжил , гадаадад хөдөлмөр эрхлэлт, хүн ам, шилжих хөдөлгөөн, цаг агаар, экологи зэрэг олон асуудлуудыг олон улсын хэмжээнд авч үзэх шаардлагатай болж байна.

2.2 Монгол улсын нийгэм-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төрийн бодлогын арга хэрэгсэлүүд, бодлогын хэрэгжилтийн үр дүн

Монгол улсын төрөөс эдийн засаг - нийгмийн салбарт явуулж буй бодлого, түүний үр дүнг дараахь асуудлуудын хүрээнд судалсан болно. Үүнд:

1. Эдийн засаг дахь төрийн үүрэг роль, оролцоо
2. Эдийн засгийн шинэчлэлийн стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
3. Төрийн санхүү, төсвийн бодлого
4. Мөнгө зээлийн бодлого
5. Монополийн эсрэг бодлого
6. Валютын ханш, гадаад худалдааны бодлого
7. Хөрөнгө оруулалтын бодлого
8. Нийгмийн салбарын бодлого

а/ Эдийн засаг дахь төрийн оролцоо

Зах зээлийн харилцааны үед төрийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оролцоо ямар байх вэ, ямар арга хэрэгсэлүүдээр дамжуулан төрийн зохицуулалтын механизмууд ажиллах вэ, төрийн оролцооны зохистой хязгаар ямар байх вэ? зэрэг асуудлууд судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн. Монгол улсын эдийн засаг-нийгэмд төрийн гүйцэтгэж буй үүрэг роль, оролцоо ямар байгаа, шшний эерэг сөрөг нөлөөөл нь ямар байж болохыг судалгаагаар харуулахыг зорилоо. Асуудлыг дараахь хэд хэдэн үзүүлэлтүүдийн харьцаагаар тодруулав. Үүнд:

Зураг 1. ДНБ-д Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцлийн эзлэх хувь



* * *

Дүгнэлт:

Судалгаанаас үзэхэд эдийн засагт төрийн оролцоо өндөр байгаа нь харагдаж байна. 2003 оноос хойшхи үзүүлэлтээр, ДНБ-д эзлэх төсвийн орлогын дунджаар 37%, зарлага - 40%, төсвийн алдагдал- (-2.0%) байна. Бусад орнуудтай харьцуулахад ДНБ/ Төсвийн зарлагын харьцаа харьцангуй өндөр байна./ Тухайлбал, орлогын тундаж түвшинтэй 11 орны дундаж үзүүлэлт - 14% байна.[87] Үүнээс үүдэн дараахь дүгнэлтийг хийж байна.

1. Эдийн засагт төрийн оролцоо харьцангуй өндөр байна. ДНБ/ Төсвийн зарлагын харьцаанаас үзэхэд нийгмийн баялгийн үйлдвэрлэлийн хэмжээ бага, төсвөөр дамжуулан эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж буй нөлөөлөл, төрийн оролцоо өндөр байгаа нь бодит үйлдвэрлэлийг дэмжих бус хэрэглээг дэмжсэн, үр ашиггүй бодлого байх талтай.
2. Эдийн засагт төрийн оролцоо өндөр байх тусам нь хүнд суртал, авилгал нэмэгдэх хандлагатай.

1.2. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, төрийн оролцоо

Хүснэгт 2.

- Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй нийт ААН, төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой ААН, тэдгээрийн эзлэх хувь

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО /хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст/				
Хариуцлагын хэлбэр	2007	2008	2009	2010
Компани	38 011	43 130	46 893	55 996
Төрийн өмчит үйлдвэрийн газар	562	651	660	557
Хоршоо	3 223	2 595	2 681	2 563
Нөхөрлөл	3 801	3 174	3 304	3 303
Төсөвт байгууллага	4 191	4 044	4 047	4 410
Төрийн бус байгууллага	6 050	6 858	6 908	6 915

[87] И.М. Албегова и др. “Государственная экономическая политика”, 1998, Москва,стр33

Бусад (хувийн цэцэрлэг, сургууль г.м)	63	83	81	78
БҮГД	55 901	60 535	64 574	73 822

2010 оны статистик мэдээлэлд дурьдсан Аж ахуйн нэгж, байгууллагын улсын нэгдсэн тооллогын дүнгээр нийт 73822 ААН бүртгэгдсэнээс, төрийн өмчит үйлдвэрийн газар 557 (0.7 хувь), төсөвт байгууллага-4410 (5.0%) байна. Тооны хувьд хувийн хэвшлийн ААН нэгж давамгайлсан мэт харагдавч бодит байдалд ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь хэмжээ, жижиг дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр харьцангуй бага байгаа нь харагддаг. Улсын бүртгэлд бүртгэлтэй ихэнх ААН идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь судалгаанаас харагдсан.

5. Эдийн засгийн шинэчлэлийн стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

Монгол улс 1990 онд зах зээлийн харилцаанд шилжих үедээ хөгжлийн бодлого, стратегийн хувьд огцом өөрчлөлт буюу “ шоковая терапия” бодлогыг хэрэгжүүлсэн гэж үздэг. Тухайлбал, өмч хувьчлал, үнийн либеральчлал, гадаад худалдааг чөлөөлөх валютын ханшийг чөлөөлөх, хувийн хэвшлийг дэмжих зэрэг бодлогын арга хэмжээнүүдийг авч зах зээлийн харилцааны суурь бүтцийг бий болгох, улмаар эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээнүүдийг авч ирсэн байна. 1996 оноос эхлэн үндэсний хэмжээний томоохон бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийг батлан гаргасан байна.

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод-суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” -д тусгасан эдийн засгийн бодлогын гол зорилт нь 2007-2015 онд “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 14 хувьд, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 5 мянгаас доошгүй ам. долларт хүргэж, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавих зорилтыг дэвшүүлсэн байна.

Хүснэгт 3.

- ДНБ-ний өсөлт, бууралт:

Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд	1995 он	2000 он	2005 он	2009 он	2010 он
ДНБ-оны үнээр /тэрбум төг/	550.2	1.172.7	2524.3	6590.6	8255.1
Нэг хүнд ногдох ДНБ /оны үнээр / төгрөгөөр/	246.1	426.2	899.3	2432.3	2992.8
ДНБ-ны өсөлт	2,4	1,1	7,3	-1,3	6,1

* * *

Дүгнэлт:

2007 оноос хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш дээрхи үзүүлэлтүүд харьцангуй бага байгаагаас үзэхэд 2015 он гэхэд бодлогын зорилтууд хэрэгжих магадлал бага байна. Уул уурхайн салбарын өсөлтөөс шалтгаалан үзүүлэлтүүд харьцангуй сайжирч болох юм.

в/ Төрийн санхүү, төсвийн бодлого, төлөвлөлт

Хүснэгт 4. Улсын нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд

	2008	2009	2010	2011 тод	2012 төс
Нийт орлого	2170,3	1993,9	3122,5	3919,9	6352,2
Нийт зарлага	2466,7	2314,2	3080,7	4912,3	7093,0
Хөрөнгийн зардал	624.4	460.5	590.6	1187.0	2 390.9
Гадаад худалдааны тэнцэл /сая.ам.долл/	-710.1	252.3	-291.6	-	-
Нийт тэнцэл	-296,4	-341,2	417,8	-992,4	-740,9

Сүүлийн жилүүдэд төсвийн зардал үлэмж хэмжээгээр нэмэгдэж, төсөв огцом тэлэх хандлагатай байна. өмнөх жилүүдэд төсвийн зарлагын өсөлт өндөр байсан хэдий ч 2012 оны төсөвийн төсөлд тусгагдсан шиг өндөр үзүүлэлт байгаагүй юм. Төсвийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 32,8% иар нэмэгдүүлэхээр төлөвлөсний дийлэнхийг татварын орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Сүүлийн 2 жилд орлогын албан татвар буурсан бол НӨАТ-ын орлого өссөн байна.

2012 онд гаалийн татвар/56,6%/, тусгай зориулалтын орлого /46,1%/ нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь хэмжээ 2012 онд 39,4% болж Засгийн газрын 33%-иас хэтрүүлэхгүй байх бодлогоос давж төсөвлөгдсөн байна. 2012 онд төсвийн тогтворжилтын санд 381,2 тэрбум төгрөгийг /42% нэмэгдүүлэх/ төвлөрүүлэхээр, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас 1669,5 тэрбус төгрөг төвлөрүүлэхээр тусгасан нь нийт тэнцвэржүүлсэн орлогын 42%-ийг эзэлж байна.

2002 онд ашигт малтмалын экспорт нийт экспортын 50% -ийг эзэлж байсан бол 2010 онд 90% орчим эзэлж байна. 2012 онд төсвийн нийт орлого 61.7 % -иар, төсвийн нийт зарлага 69.2%-иар, хөрөнгө оруулалтын зардал 49.6%-иар нэмэгдэхээр тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт 5 .**Төсвийн алдагдалын санхүүжилт**

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011 тод	2012 төс
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	39.4	-73.3	-123.4	-133.2	296.4	342.6	-41.8	992.4	740.9
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	12.5	-135.2	-126.4	181.3	275.0	-464.0	-182.6	-3.8	-162.0
2. МУХС-гаас улсын төсөвт шилжүүлэх	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	168.5	0.0	0.0
3. Засгийн газрын бонд	-61.0	-25.8	-94.4	-16.4	-20.3	623.5	114.7	337.0	-83.5
4. Засгийн газрын зээл	71.7	82.9	67.3	46.8	32.9	209.6	24.5	83.5	-491.1

5. Урьдчилгаа төлбөр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	414.2
6. Өмч хувьчлал	16.2	5.0	30.1	17.7	8.8	-26.5	3.5	114.8	1,263.3

Төсвийн алдагдалын дийлэнхийг 2012 онд өмч хувьчлалын орлого, ЗГ-ын зээл болон урьдчилгаа төлбөрийн эх үүсвэрээр нөхөхөөр төсвийн төсөлд тусгасан байна. Судалгаанаас үзэхэд, Засгийн газрын өрийн удирдлагад анхаарал хандуулах цаг болсон нь харагдаж байна.

г/ Мөнгө- зээлийн бодлого

Сүүлийн жилүүдэд эдийн засаг өсч байгаа боловч инфляцийн түвшин зорилтот түвшингөөс хэтэрч 10-аас дээш хувьтай гарсаар байгаа тул Монголбанк мөнгөний бодлогоо чангаруулах арга хэмжээ авч байна.

Монгол банк 2008 оноос эхлэн инфляцийг онилох буюу инфляцийг тогтвортой доогуур түвшинд барихад чиглэгдсэн бодлого явуулж ирсэн. Инфляцийг онилох бодлогын гол хэрэгсэл нь Төв банкны бодлогын хүү юм. Төв банкнаас бодлогын хүүг нэмэгдүүлэх арга хэмжээг удаа дараа авахаас аргагүй байдалд хүрсэнийг Засгийн газрын үйл ажиллагаа, төсвийн тэлэлттэй холбон тайлбарлаж байна. Монголбанк болон Засгийн газрын хооронд бодлогын **уялдаагүй зөрчилдөөнтэй байдал** бий болж энэ нь 2012 оны төсөв, мөнгөний бодлогыг УИХ-аар хэлэлцэх явцад улам тодорхой болсон.

Бодлогын хүү:

Монголбанк 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.25 хувьд хүргэх шийдвэр гаргасан. ҮСХ-ноос мэдээлснээр 2011 оны 9 дүгээр сарын байдлаар ХҮИ-ээр хэмжсэн инфляци улсын хэмжээнд жилийн 10.5 хувь, Улаанбаатар хотынх жилийн 11.9 хувьд хүрээд байгаа бөгөөд төсвийн зардал хурдтай тэлж, Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож, зээлийн өсөлт хурдасч байгаа зэрэг нь нийт эрэлтийг нэмэгдүүлж байна. Нийт нийлүүлэлт болон эдийн засгийн бодит хүчин чадал дорвитой өсч амжаагүй байхад нийт эрэлт ийнхүү огцом өсөх нь суурь үнэ өсөх дарамтыг бий болгож байгаа тул бодлогын хүүг нэмэхээс өөр аргагүйд хүрсэн гэж Монголбанк тайлбарлаж байна. Харин бодлогын хүү өсөхөд бусад хүү болон арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүү дагаж өөрчлөгдөх ба энэ нь бодит секторын санхүүжилтийг хязгаарлах болно.

Хүснэгт 6: Монголбанкны хүү, жилийн хувь

Хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн	Бодлогын хүү	Репо	Овернайт	Барьцаат зээл
2011.10.25	12.25	16.25	21.25	20.25
2011.08.29	11.75	15.75	20.75	19.75
2011.04.28-6.23	11.50	15.50	20.50	19.50
2010.05.12 - 2011.2.24	11.00	15.00	20.00	19.00
2009.09.30	10.00	14.00	19.00	18.00
2009.06.12	11.50	17.50	21.50	20.50

2009.05.12	12.75	18.75	22.75	21.75
2009.03.11	14.00	17.00	21.00	20.00
2008.11.19	9.75	18.00	23.00	13.86
2008.09.10 - 2011.11.13	10.25	18.00	23.00	13,86
2008.03.19	9.75	18.00	23.00	
2007.11.21	8.40	18.00	23.00	
2007.10.17	7.40	18.00	23.00	
2007.07.09	6.40	18.00	23.00	

Эх сурвалж: http://www.mongolbank.mn/dblistmongolbankrate.aspx

Инфляцийн түвшин:

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд дурьдсанаар хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тоонд буюу 10 хувиас хэтрүүлэхгүй байхаар, 2013-2014 онд 8 хувиас хэтрүүлэхгүй байхаар тусгасан байна. Бусад орнуудын инфляцийн түвшинтэй харьцуулахад 10 хувь гэдэг хэдий өндөр боловч манай орны нөхцөл байдалд үүнээс нам зорилт дэвшүүлэх боломжгүй хэмээн Монголбанк үзэж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар үндсэн чиглэлд тусгасан инфляцийн түвшин болон үр дүнг харьцуулбал:

Хүснэгт 7. Инфляцийн зорилтот түвшин, үр дүн

Үзүүлэлтүүд	Үндсэн чиглэлээр батлагдсан инфляцийн зорилтот түвшин	Гүйцэтгэлээр гарсан үр дүн буюу инфляцийн түвшин	Төв банкны бодлогын хүү	Төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь	ДНБ-ний өсөлт хувь
2007 он	5,0	17,8	7,4	37,9	10,2
2008 он	6,0	22,1	10,25	40,2	8,9
2009 он	<10%	4,2	14,0	48,6	-1,3
2010 он	<10%	13,0	11,0	43,3	6,1
2011 он ХБГ	<10%	11,9	12,25	52,1	20,0
2012 он төсөөлөл	<10%	-	-	39,4	25,6

*2011 оны эхний 9 сарын байдлаар

Хүснэгтээс үзэхэд 2007-2008 онуудад инфляцийн түвшин үндсэн чиглэлд тусгасан зорилтот түвшнээс 3,0-3,5 дахин их гарсаныг судлаачид эдийн засгийн хямралтай холбон тайлбарладаг. Инфляцийг 10-аас доош хувьд барих зорилт зөвхөн 2009 онд л хэрэгжсэн байна.

1.1 Нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт 8

	1995 он	2000 он	2005 он	2009 он	2010 он
Суурин хүн амын тоо /мян.хүн/	2 243.0	2 407.5	2,562.4	2,735.8	2780.8
Эдийн засгийн идэвхтэй хүн / мян. хүн/	812.7	847.6	1001.2	1137.9	1147.1
Үүнээс: Ажиллагчид	767.6	809.0	968.3	1006.3	1033.7
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	45.1	38.6	32.9	38.1	38.3
Ажилгүйдлийн түвшин % -аар	5.5	4.6	3.3	3.3	
ААН байгууллагын ажилчдын дундаж цалин /мян.төгрөгөөр/		62.3	101.2	300.5	379.4
Хүн амын амьжиргааны доод түвшин /мян.төг/	8000	19300	30000	101100	101600
Нэг өрхийн сарын дундаж орлого /мян.төгрөгөөр/	38.3	92.1	172.0	402.5	448.0
Нэг өрхийн сарын дундаж зарлага /мян.төгрөгөөр/	38.3	111.8	194.0	437.6	450.2

Нийгмийн хөгжлийн статистик мэдээллээс үзэхэд, хүн амын амьжиргааны түвшин, өрхийн сарын дундаж орлого болон дундаж цалин өссөн, ажилгүйдлийн түвшин буурсан харагдаж байгаа боловч инфляцийн түвшин, өрхийн зарлагын түвшинтэй харьцуулахад энэ нь хангалтгүй үзүүлэлт юм.

Төрийн бодлого ба иргэдийн оролцоо

Парламентаас батлагдсан хууль, бодлогын баримт бичгүүд бодитойгоор хэрэгжиж иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэгдсэн байх ёстой. Сүүлийн жилүүдэд бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэний нийгэм, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудал ихээр хөндөгдөх боллоо. Олон улсын байгууллагууд, иргэний нийгмийн шахалтаар ардчилсан засаглалын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар тодорхой алхамууд хийгдэж байна.

Энэ асуудалд ОУБ болон судлаачид, парламентын зүгээс тодорхой хэмжээнд анхаарал хандуулж байна. Тухайлбал:

- 2007 онд ННФ, УИХ-ын Тамгын газар хамтран “Хууль боловсруулах, хэлэлцэх явцад иргэдийн оролцоо” сэдэвт олон улсын хурлыг зохион байгуулсан
- 2004 онд НҮБХХ, Монгол Улсын Их Хурал хамтран “ Ардчилсан засаглалын парламентыг бэхжүүлэх” хамтарсан төслийг хэрэгжүүлж Монгол Улсын Их Хурал болон УИХ-ын Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх талаар судалгаа хийж санал, зөвлөмж боловсруулсан
- 2006 онд ННФ-ийн бодлогын тэтгэлэгт судлаач Ч. Тамир нар “Парламентад бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт бодлогын судалгааг гүйцэтгэсэн байна.

Мөн УИХ болон Засгийн газрын түвшинд засаглалын чадавхийг сайжруулах, сайн засаглалыг дэмжих чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөрүүд нэлээд хэрэгжиж байна. Монгол Улсын Их Хурлын хувьд УИХ -ын хууль тогтоох, хянан шалгах, төлөөллийн чиг үүргийн хэрэгжүүлэх арга механизмуудыг боловсронгуй болгох, урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан мөрдүүлэх арга хэмжээнүүдийг авч байна. Тхуайлбал:

- 2002 онд УИХ -ын тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө”
- 2004 онд УИХ-ын Тамгын газрын чиг үүргийн матриц , үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө/бизнес стратеги/ зэргийг батлан гаргаж эдгээр бодлогын баримт бичигт заасны дагуу УИХ-ын хууль тогтоох, бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

УИХ Болон УИХ-ын Тамгын газрын түвшинд дээрхи нөхцөл байдалтай уялдуулан бүтцийн өөрчлөлт хийж УИХ-аар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах үүднээс бодлогын судалгаа, мэдээлэл, лавлагаагаар шуурхай хангах, парламентыг олон нийтэд нээлттэй байлгах , олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор парламентын албан ёсны мэдээллийн телевизийг ажиллуулах, Байнгын хороны түвшинд нээлттэй сонсгол, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, иргэд олон нийтээс хуулийн төсөлд өгч буй саналуудыг вэб сайт болон бичгээр хүлээн авч УИХ-ын гишүүд, Байнгын хороодод хүргүүлэх зэргээр ажиллаж байна. Тухайлбал:

- УИХ-ын Тамгын газрын бүтцэд Судалгаа, шинжилгээний алба
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
- Хууль сурталчлах алба байгуулж эдгээр нэгжүүд нь олон нийт, парламентыг холбох чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Гэвч практикаас үзэхэд, төр-иргэн хоорондын харилцааг бий болгох, олон нийттэй харилцах ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн оновчтой механизм, арга хэрэгсэлүүд дутагдалтай байгаа нь харагдаж байна. УИХ-аар батлагдан гарч буй хууль тогтоомжууд нь нийгмийн эрэлт шаардлагад нийцээгүй, тухайн зах зээлийн харилцааны эрх зүйн хэм хэмжээг оновчтой зохицуулж чадаагүй, Үндсэн хууль болон бусад хуультай зөрчилдөх, олон улсын стандарт нийтлэг хэм хэмжээтэй зөрчилдөх зэрэг дутагдалууд байсаар байна.

Бодлого боловсруулах, хууль санаачлах эрх бүхий субьектууд бүгд энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. УИХ-д өргөн баригдаж буй хууль болон бодлогын шийдвэрийн төслийн дийлэнх нь Засгийн газрын түвгинд боловсруулагдсан байдаг. Иймд анхан шат/ Засгийн газар/ болон хэлэлцүүлгийн шат /УИХ/ -ын түвшинд аль алинд нь иргэд, судлаачдын оролцоог хангах оновчтой систем бүрдсэн байх ёстой. Энэхүү тогтолцоог бий болгох нь хууль санаачлагчид, бодлого боловсруулагчдаас өөрсдөөс нь ихээхэн шалтгаална. Иймд бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүх шатанд иргэдийн оролцоог хангах үүднээс дараахь асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй юм.

“Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 18-р зүйлд зааснаар “... хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана гэж заасан байдаг. Иргэн, хуулийн этгээдээс санал авахдаа дараахь аргуудыг хэрэглэнэ хэмээн хуульд заасан байдаг. Үүнд:

- Хуулийн төслийг бүрэн эхээр нь цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах

- Хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулах хэлбэрээр явуулах.

2009 оны 6-р сард орсон нэмэлт өөрчлөлтөөр хууль санаачлагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуулийн төслийн танилцуулгад тусгана хэмээн заасан боловч одоогоор хэрэгжилт хангалтгүй байна.

Практикт иргэдээс дорвитой санал ирүүлэхгүй байх ба вэб хуудсанд хуулийн төслийн танилцуулах, тодорхой асуудлаар хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах, ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийж хууль болон шийдвэрт тусгах эсэхийг Байнгын хороодоор хэлэлцэх , иргэдтэй эргэх холбоо тогтоох зэрэг асуудлууд хангалтгүй байна.

Зарим орнуудын туршлагаас үзэхэд, хуулийн төсөл боловсруулах шатанд Засгийн газрын түвшинд олон нийтийн оролцоог хангах ажиллагааг зохион байгуулдаг байна. Учир нь хуулийн төсөл боловсруулах ажил нь ихэнхи тохиолдолд Засгийн газрын холбогдох яамдын “Хуульчдийн зөвлөл”-өөр хийгддэг ажээ. Ингэхдээ тухайн хуулийн зорилтот бүлгүүдэд бүлгийн ярилцлага хийх, уулзалт зохион байгуулах болон иргэдийн саналыг электрон шуудангаар авдаг байна. Харин мэргэжлийн судлаачид буюу экспертийн түвшний оролцоог хэлэлцүүлэг явуулах хэлбэрээр саналыг нь авдаг байна.

Зарим орнуудад /Польш, Румын, Эстони, Словак, Чех/:

- мэдээлэх /албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, вэб сайтад байршуулах гэх мэт/
- зөвлөлдөх /нээлттэй хэлэлцүүлэг явуулах, эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс санал авах, практик зөвлөмж авах гэх мэт/
- идэвхитэй оролцоог хангах /иргэд өөрсдөө хууль санал болгох, ажлын хэсэгт ажиллах, санал солилцох/-иргэд ажлын хэсэгт ажиллах зэргээр оролцоог хангах арга хэмжээнүүдийг авдаг байна.

Дүгнэлт, зөвлөмж:

1. Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах хүрээнд:

Монгол улс 21 -р зууны босгон дээр дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын баримталж буй социал демократ үзэл баримтлал буюу нийгмийн ардчилсан үзэл баримтлалыг төрийн бодлогын суурь үзэл баримтлалаа болгох хандлагатай байна. Гэвч эдийн засгийн онолын сургаалиуд төлөвшин бий болсон байдал, шилжилтийн эдин засагтай орнуудын сайн туршлага, өндөр хөгжилтэй орнуудын туулж өнгөрөөсөн эдийн засгийн түүхээс үзэхэд нийгмийн баримтжаатай эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн баялгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, материаллаг хүчин чадал, эдийн засгийн нөөц боломжийг тогтвортой нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн зөв бүтэц, зах зээлийн хэвийн орчинг бүрдүүлэх шаардлагатай болох нь судалгаанаас харагдаж байна.

Социал демократ үзэл баримтлалд зарим улс төрчид, судлааид шүүмжлэлтэй ханддаг. Учир нь хэт улс төржсөн байдлаар нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөхүйц амлалт өгч, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө бодлогогүй алхамуудыг хийх нь улс орны дотоод нөөц боломжоос давсан, эмх цэгцгүй, ойлгомжгүй бодлогын орчинг бий болгож улмаар хямралд хүргэх аюултай хэмээн үзэж байна.

2. Төрийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилт, үр дүн, уялдаа холбоог сайжруулах хүрээнд:

- Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах. Төрийн

бодлогын суурь концепц, түүнд нийцүүлэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэл, онолын чиг баримжаа болон практик үр дүнг тодорхой болгож, бодлого, зорилтуудыг зөв тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэрэгсэлүүдийг зөв тодорхойлох

- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах. Монгол улсад ижил зорилго, чиглэл бүхий маш олон бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа боловч тэдгээр нь агуулга, зорилтын хувьд давхардсан, эсвэл бие биенээ үгүйсгэсэн, уялдаа холбоо муутай байна гэх шүүмжлэл нэлээд гарч байна
- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох. УИХ болон Засгийн газраас батлан гаргаж буй бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байдгаас хэрэгжилт нь хангалтгүй байдаг. Улс төрийн амлалт, нийгмийн сэтгэл зүйд нийцүүлэх хандлагатай олон янзын бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд цаасан дээр батлагдсан боловч хэрэгжих боломжгүй байсаар байна.
- Хяналт шинжилгээ - үнэлгээг сайжруулах. Сүүлийн үед төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарсан уламжлалт аргаас үр дүнд суурилсан хяналт шинжилгээ-шнэлгээний аргад шилжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар бодлого, хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн боловч хүсэн хүлээсэн үр дүнг бий болгож чадсан уу? гэдгийг анхаарах шаардлагатай. Үүний тулд төсөл, хөтөлбөрийн үр дагавар, үр нөлөөг тооцон гаргаж цаг хугацааны явцад зорилт биелэгдсэн эсэх, хэрхэн биелэгдэв гэдэгт хариулт өгөх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
- Иргэдийн оролцоог хангах. Ардчилсан засаглалын суурь зарчим болох сайн засаглал, хариуцлагатай, ил тод, нээлттэй байдлыг бий болгох үүднээс төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудал чухал юм. Хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох, нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад иргэд, олон нийтийн оролцоо чухал бөгөөд төр засгийн зүгээс гадад, дотоодын оролцогч талуудаас тавьж буй шахалт, шаардлагад илүү мэдрэмжтэй хандах шаардлага бий болж байна.
- Дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах. Дэлхий дахины эдийн засаг, зах зээлийн харилцаанд хүн амын, мэдээлэлийн болон бараа бүтээгдэхүүний асар их шилжилт хөдөлгөөн гарч хил хязгааргүй урсгалд татагдан орох даяаршилын шинэ нөхцөл байдал бүрдэж байгаа учраас хүн ам, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийн бодлого нь дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн үйл явцтай нягт уялдах шаардлагатай болж байна. дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал, хөрш орнуудын нөлөөлөл, уул уурхайн салбарын хөгжил , гадаадад хөдөлмөр эрхлэлт, хүн ам, шилжих хөдөлгөөн, цаг агаар, экологи зэрэг олон асуудлуудыг олон улсын хэмжээнд авч үзэх шаардлагатай болж байна.

3. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

- Бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах бүх түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын хэмжээнд зохион байгуулалтын арга механизмуудыг тодорхой болгож, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүнг сайжруулах
- Хууль болон бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах хэлэлцэн батлах шатанд иргэний нийгэм, хууль хэрэгжүүлэгч субьектүүд, зорилтот бүлгийн төлөөлөгчидтэй газар дээр нь уулзаж ярилцах, идэвхтэй хэлэлцүүлэг,

мэтгэлцээн өрнүүлэх хэлбэрийг өргөн ашиглах

- Иргэд, олон нийт, судлаачдын саналыг Ажлын хэсэг, Засгийн газар, УИХ-ын түвшинд зайлшгүй хэлэлцэж төсөлд тусгах эсэхийг шийдвэрлэх, энэ тухай эргэж хариу мэдэгдэх эргэх холбоог бий болгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Иргэд олон нийтэд төрийн бодлогыг таниулах, хууль хэрэгжүүлэх, дагаж мөрдөхтэй холбоотой хялбаршуулсан заавар зөвлөгөө өгөх ажиллагааг УИХ, Засгийн газрын түвшинд зохион байгуулах
- Төр-иргэний нийгмийн харилцаагдэмжсэн институциональ дэд бүтэц/ мэдээллийн суваг, үйлчилгээний систем, иргэний танхим, эрдэмтдийн зөвлөл гэх мэт/ -ийг байгуулж идэвхтэй ажиллуулах
- Төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд шинжлэх ухааны байгууллагууд/ ЭШХ, судалгааны институт, эрдэмтэн, судлаачид, think thank/ -ыг сайтар оролцуулж, бодлогын шинжтэй томоохон асуудлуудаар мэргэшсэн судалгааны байгууллагуудаар судалгаа шинжилгээ хийлгэх
- Төрийн үндсэн институцийн бүтцэд болон харьяанд ажиллаж буй судалгааны шинжилгээний нэгж, институтуудийг чадавхижуулж, академик болон суурь судалгааны байгууллагуудтай нягт уялдаатай ажиллуулах, олон улсын болон дотоодын мэдээллийн баазад хандах, мэдээлэл солилцох, мэдээллийн урсгалыг сайжруулах арга хэмжээ авах